



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 622

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 5,911,891,221.00 (таван тэрбум есөн зуун арван нэгэн сая найман зуун ерэн нэгэн мянга хоёр зуун хорин нэгэн) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчит компаниуд болон Баян-Өлгий, Хэнтий аймгийн өмчид тус тус бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, төрийн өмчит хувьцаат компаниудын гүйцэтгэх захирал, Баян-Өлгий, Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА


 Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон төрийн болон орон өмчит бүртгэх
хөрөнгийн жагсаалт

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хөрөнгийн дүн /төгрөг/	Гүйцэтгэгчийн нэр	Ашиглагч байгууллагын нэр
1	Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт /улсын хэмжээнд/ багц-14	970,000,000.00	Нью оптик ХХК	ЭБЦТС ТӨХК
2	Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт /улсын хэмжээнд/ багц-5	867,000,000.00	АУЭХС ТӨХК	АУЭХС ТӨХК
3	Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт /улсын хэмжээнд/ багц-17	896,852,865.00	Жи пауэр ХХК	АУЭХС ТӨХК
4	Нийслэлийн гэр хорооллын цахилгаан шугам сүлжээ, дэд станцыг өргөтгөж хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгө буюу 20.000 айл өрхийг 4.0 кВт чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх ажил /багц-25/	312,524,995.00	Техникийн цогц шийдэл ХХК	УБЦТС ТӨХК
5	Нийслэлийн гэр хорооллын цахилгаан шугам сүлжээ, дэд станцыг өргөтгөж хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгө буюу 20.000 айл өрхийг 4.0 кВт чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх ажил /багц-27/	1,621,533,915.00	Бридж констракшн ХХК	УБЦТС ТӨХК
6	Цахилгаан дамжуулах агаарын шугам, 0.4 кВт /Баян-Өлгий, Толбо сум/	589,865,302.00	Хайрхан наран трейд ХХК	Баян-Өлгий аймгийн ЦШСГ ОНӨААТҮГ
7	Сумын төвийн 0.4 кВ-ын шугамын шинэчлэлт /Төв, Баянцагаан сум/	355,025,728.00	Хустайн шил ХХК	УБЦТС ТӨХК
8	Нэгдсэн халаалтын шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум, Тахилгат тосгон/	299,088,416.00	Эрчим өргөө ХХК	Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат тосгоны захирагчийн ажлын алба
Нийт дүн		5,911,891,221.00		
		(таван тэрбум есөн зуун арван нэгэн сая найман зуун ерэн нэгэн мянган төгрөг хоёр зуун хорин нэг)		